



“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ-Т

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,
Цахим шуудан: contact@afccp.gov.mn,
Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024-06-07 № 01/1081

танай _____-ны № _____-т

**Тендерийн баримт бичиг
хянасан тухай**

Танай үйлдвэрээс зарласан “MP800, C200, MP400 бутлуурын сервис үйлчилгээний ажил” ЭҮТӨҮГ/20240101730 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичигт “Их Энерги” ХХК-аас гомдол ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хяналаа.

Тендерийн баримт бичгийн ТШЗ 19.2.1-д “Ажил гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн мэдээлэл “Шаардана” гэж, “Инженер техникийн ажилтнуудын нийгмийн даатгалын шимтгэлийг сүүлийн 3 сар тендерт оролцогч аж ахуйн нэгж тасралтгүй төлсөн байх” гэж тус тус заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална” гэж, 17 дугаар зүйлийн 17.1-д “Захиалагч техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг оролцогчоос шаардаж болно” гэж, 17.2.3-т “Гэрээний үүргийн гүйцэтгэлийг хариуцах ажилтны нэр, боловсрол, мэргэжлийн ур чадварын мэдээлэл;” гэж, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/259 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан. “Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг тендер баримт бичиг”-ийн ТШЗ 19.1-д “Техникийн чадавх болон туршлагын шаардлага “Шаардана” эсхүл “Шаардахгүй” аль нэгийг сонгож бичнэ. Хэрэв шаардах бол дор дурдсан шаардлагаас гэрээний үүргийн гүйцэтгэлд ач холбогдол бүхий шаардлыг тусгах ба үүгээр хязгаарлагдахгүй” гэж, ТШЗ 19.2-т “Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг”, ТШЗ 19.1-д заасан шаардлагыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичгийг хуулийн 17.2-т заасан баримт бичгээс сонгож бичнэ.” гэж тус тус заасан байна.

0002365

Захиалагч тендерийн баримт бичгийн ТШЗ 19.2.1-д заасан шалгуур үзүүлэлтийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасны дагуу боловсруулсан байна.

Иймд тус тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулна уу.

ДАРГА



Б.БИЛГҮҮН